



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гүйцэтгэх захирлын 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 201 дугаар тушаал, "Дэлгэрхангай секюритиз" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжаанд оролцох эрхийг сэргээлгэх тухай 2014 оны 12 дугаар сар 11-ний өдрийн 41 тоот болон 2014 оны 12 дугаар сар 15-ны өдрийн 45 тоот хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Дэлгэрхангай секюритиз" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Дэлгэрхангай секюритиз" ХХК /М.Бат-Оргил/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР